

## Монгол дахь Америк судлалын үүсэл, байдал

*проф. Н. Ишжамц,  
Монголын АНУ судлалын төвийн тэргүүн*

1997 оны тавдугаар сарын 8

Америк судлал бол АНУ-ын иргэд янз бүрийн хэл, соёл, заншил бүхий нэгдмэл нэг үндэстний хувьд ардчилал, эрх чөлөө, хүний эрх, зах зээлийн нөхцөлд хэрхэн үүссэн бүрэлдэж, амьдарч хөгжиж ирсэн зэргийг хүмүүнлигийн үүднээс шинжлэн судалж, дүн шинжилгээ хийдэг өвөрмөц шинж, нийтлэг ач холбогдол бүхий нэгэн зүйл нийгмийн шинжлэх ухаан юм.

Америк судлал анх 1930-аад оны үест АНУ-д үүсч 60 орчим жилийн дотор хэд хэдэн үе шат дамжиж хөгжин дэлхийн улс орнуудад дэлгэрч олон улсын хоорондын судлагааны шинжтэй болсон байна.

Эхний үед америкчуудын зөвхөн хэл, соёл, урлагийн асуудлыг голлон анхаарсан, мэргэжил тус бүрээр дагнасан /diverse disciplines/ судалгаа байжээ.

Дэлхийн II дайны дараа Америкийн түүх, газар зүй, эмэгтэйчүүдийн асуудал, янз бүрийн арьстан, ястнуудын соёл заншлыг хамарсан олон талт /multidisciplinary/ судалгаа болжээ. 80-аад оны эцэс, 90-ээд оны эхнээ улс үндэстэн тус бүрийн эдийн засаг, зах зээл нь үндэстний хүрээнээс хальж хөгжин үндэстэн хоорондын, олон улсын шинж чанартай болж ирээд ялангуяа ЗХУ задарч, хүйтэн дайны үе эцэс болсны дараа америк судлал нь шинэ нөхцөлд зохицож, олон янзын мэдлэг, мэргэжил хосолсон иж бүрэн цогцолбор /thoroughly interdisciplinary, integral, complex/ шинжилгээ судалгаа болж хөгжих замд оржээ. Орчин үед америк судлалын цар хүрээ тэлж, судалгааны чанар чиглэл нь улам нарийсан ямарваа нэг улс орон юмуу бүс нутаг ерөнхийлөн судлахаасаа илүү АНУ-ын холбогдол бүхий олон улсын улс төр, эдийн засаг, соёл урлаг, зан заншил, ёс суртахууны

шийдвэрлэгдээгүй байгаа асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн нягтармал судалгаан дээр голлон анхаарч шийдвэрлэх асуудал барьсан /problem-focused/ бясалгал бодрол багтаамжит /think-tank/ шинжилгээ судалгаанд голлон анхаарах болж байгаа байна.

Энэ бүхний учир америк судлалын хүч нөлөө, ач холбогдол жилээс жилд нэмэгдэн Баруун Европ, Япон, Энэтхэг, Солонгос, Орос, Хятад цөм америк судлалын ихээхэн хүчирхэг төвүүдтэй болсон байхад 80-аад оны эцэс, 90-ээд оны эх хүртэл ганцхан Монгол улс л ямар ч америк судлалгүй үлдсэн мэт санагддаг.

Гэсэн ч 70-аад оны эцэс, 80-аад оны дунд үеэс БНХАУ, ЗХУ, Монгол улсын зэрэг социалист орнуудад өөрчлөлт шинэчлэлийн эрин үе эхэлж, 1987 онд Монгол, Америкийн хооронд албан ёсны дипломат харилцаа тогтоод 1990 онд Монгол, Америкийн нийгэмлэг байгуулагдсан зэрэг нь манай оронд өөрийн гэсэн америк судлал үүсэн бий болох урьдчилсан нөхцлийг бүрэлдүүлж өгсөн юм.

### *Төвийн үүсэл, зорилт, зохион байгуулалт*

1991 оны 1-р сарын 23-нд Монгол улсын Ерөнхийлөгч П.Очирбат, АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Бүүш нарыг Цагаан ордонд уулзсан тэр өдөр ШУА-ийн Дорнодахин, Олон улс судлалын хүрээлэнгийн захирал, дэд доктор Ц.Батбаяр, С.Ишдорж, Р.Отгон, М.Хурметхан, Х.Хулан нарын зэрэг эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтан нарын санаачилгаар Монголын АНУ судлалын төв байгуулагдсан юм. Тус төв академи, их дээд сургууль, бусад байгууллагын 40 гаруй эрдэмтэн, мэргэжилтэн нарыг багтаасан үзэл суртал, улс төрөөс ангид, ашиг хонжооны биш, олон нийтийн сайн дурын эрдэм шинжилгээний ассоциаци холбоо маягийн байгууллага мөн. АНУ судлалын энэ төв анхны өдрөөс эхлэн Дээд шүүхэд бүртгэгдэн зөвшөөрөгдсөн албан ёсны хуулийн эрх бүхий байгууллага, өөрийн бэлэгдэл, тамга, тэмдэг, албан бичгийн хуудас, гишүүний үнэмлэх, ажиллах дүрэм журамтай.

Монголын АНУ судлалын төвийн гол зорилго бол эерийн улсыг америк судлал, түүнийг эрхэлсэн шинжилгээний байгууллагуудтай болгох, их, дээд сургуулиуд дээр америк судлалын мэргэжилтэн бэлтгүүлж гаргах, тэгэхийн тул америкийн эрдэмтэдтэй харилцан холбоо тогтоож хамтын ажиллагаа өрнүүлэн улмаар Монгол, Америкийн ард түмний харилцан ойлгож хамтран ажиллах, Америкийн ардчилал, эрх чөлөө, хүний эрх, соёл иргэншил, шинжлэх ухаан-технологи, зах зээлийн тэргүүн туршлагаас суралцаж, сурталчлан, амьдралд нэвтрүүлж хөгжихөд дөхмийг үзүүлэхэд оршино.

Дүрмийн ёсоор Монголын АНУ судлалын төв нь зохицуулах зөвлөл, тэргүүн, зохицуулагч нарийн бичгийн дарга, зөвлөх ба бусад гишүүдээс бүрддэг. Төвийн удирдлагыг шинэчлэх сонгууль 4 жил тутамд хийгддэг. Манай төвийн зөвлөхөөр ШУА-ийн гишүүн, талийгэгч эрдэмтэн Ц.Пунцагноров сонгогдож ихээхэн идэвхи, үр өгөөжтэй ажиллаж байв. Одоо төвийн зөвлөхөөр мэргэжлийн америк судлаач, ахмад эрдэмтэн С.Индорж ажиллаж байгаа. Төвийн тэргүүнээр миний бие, дэд тэргүүнээр Олон улс судлалын хүрээлэн асны захирал, дэд доктор Ц.Батбаяр, зохицуулагч нарийн бичгийн даргаар дэд доктор хатагтай Н.Алтанцэцэг, сэтгүүлийн эрхлэгчээр дэд доктор М.Хурметхан нар тус тус сонгогдон ажиллаж байна.

Төвийн удирдлагын гол хэсэг болон гишүүдийн дөрөвний нэг нь урьдын Дорнодахин, Олон улс судлалын хүрээлэн дээр төвлөж уг төвийн үндсэн цөм болж ажилсаар ирсэн, саяхан болсон шинжлэх ухааны байгууллагуудын өөрчлөн байгуулалтын дараа Түүхийн Хүрээлэнгийн харьяанд шилжсэн Олон улс судлалын төв дээр түшиглэн ажиллах болж байна. Хүрээлэнгийн бүрэлдэхүүнд орсон, ороогүй гишүүд цөм америк судлалын ажлыг үндсэн ажлын хажуугаар нэмэгдэл цалин хөлс, урамшуулалгүй хийдэг. Тэдний цөөн хэдээс бусад нь америк судлалын мэргэжлийн хүмүүс биш, өөр чиглэлийн мэргэжилтэн нар, гэхдээ нэлээд нь америк судлалтан болохоор махран оролдож байгаа юм.

### *Төвийн шинжилгээ, судалгааны гараа, явц байдал*

Монголын АНУ судлалын төв байгуулагдмагц Америк судлалын холбогдолтой Зөвлөлт, Хятад, Америк эрдэмтдийн судалгааны зохиолтой танилцаж, сурвалж баримт, ном сэтгүүл цуглуулах зэргээр судалгааны ажлаа эхэлсэн юм.

1991 оны 5-р сард Бээжин хотноо “XX зуун дахь АНУ ба Ази, Номхон далайн бүс нутаг” сэдэвт олон улсын америк судлаачдын эрдэм шинжилгээний бага хурал болж, АНУ-ын Азийн сан хөмрөгийн бүсийн захирал асан ноён Ш.Р.Северинхаусын санхүүгийн дэмжлэгтэйгээр манай хоёр төлөөлөгч уригдан оролцсон явдал бидний ажилд ач холбогдолтой болсон билээ. Ялангуяа АНУ-д гарсан америк судлалын холбогдолтой сурвалж, баримт, судалгааны зохиол, сэтгүүл сэлт Северинхаус гуайн шугамаар Азийн сан хөмрөгөөс үе үе хүрэлцэн ирэх болсны ачаар Монголын АНУ судлалын төвийн номын сан бий болох суурь тавигдсан юм.

1991 оны дунд үеэс эхлэн Монгол дахь АНУ-ын Элчин Сайдын Яамны дэргэдэх Америкийн мэдээллийн албаны салбартай харилцаа тогтоож, зарим ном хэвлэл авах болсон.

1995 онд тус мэдээллийн алба, түүний даамал Анн Вэлдин манай төвд санхүүгийн дэмжлэг үзүүлж, Монголын АНУ судлалын төвийг бэсрэгхэн номын сан бүхий тусгай кабинеттэй болгож өгсөн. Монголын АНУ судлалын төв, зарим их, дээд сургууль америк судлалын нэлээд ном зохиолын сан хөмрөгтэй, номын сантай болоод байгаа, гэхдээ тэр бүхнээ сургалт, сурталчилгаа, мэдээлэл, судалгааны зорилгоор оюутан залуус, судалгааны ажилтан нарт тодорхой хяналт хариуцлагын доор аль болох өргөн ашиглуулж байх нь чухал болов уу. Өнгөрсөн 1996 онд Анн Дрисколл хатагтай гэргүүтэй Монгол дахь Америкийн мэдээллийн албанаас “Эх нутаг, Хилийн чанад дахь америк судлал” гэх зэрэг чухал баримт материал бидэнд ирүүлсэн нь АНУ, бусад улс оронд америк судлал үүсэн хөгжиж ирсэн түүх, ер нь америк судлал гэж чухам юу юм бэ, америк судлал одоо аль үе шатандаа ямар янзаар хэрхэн урагшилж хөгжиж байна гэдэг асуудлыг нэлээд тодруулан ойлгох боломж олгосон юм.

Судалгааны материаллаг бааз, сурвалж баримт, гарын авлага, лавлахын хувьд бид өөрийн улсын номын сан, төвийн номын сангийн баримт сэлтийг голлон ашиглаж ажилладаг. Зарим ажилтан Гадаад явдлын Яамны номын сан, архив, Гадаад харилцааны дээд сургууль, Гадаад хэлний дээд сургуулийн номын сангийн баримтанд тулгуурлан ажилладаг. Цөөн зарим нь Гадаад явдлын Яамны номын сан, Улсын архивын фонд үзэж судалгаа хийдэг. Америкийн мэдээллийн төв, түүний номын сангийн америк судлалын нэлээд баримт, техник төхөөрөмж, харилцаа холбоонд тулгуурлаж судалгаа хийх сайхан боломж байдаг боловч түүнийг хангалттай ашиглаж хараахан чадаагүй байгаа.

Судалгааны арга барилын хувьд нэн түрүү АНУ зэрэг гадаад орнуудын америк судлалын онол-арга зүй, судалгааны зохиолуудтай сайтар танилцаж, гол төлөв Монголтой холбоотой, манай орны өвөрмөц онцлог нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагад тохирсон төсөл, сэдэв сонгож харьцуулах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх арга хэрэглэж судалгаа хийхийг зорьж ирэв. Америкийн түүх, соёл иргэншил, зан заншил, ардчилал, эрх чөлөө, хүний эрхийн асуудлыг зөвхөн Баруун Европ гаралтай зүйл, түүний үргэлжлэл хөгжил гэж үзэхгүй, биеэ даасан өөр шатны, өвөрмөц соёл иргэншил хэмээн үзэж судлах арга барил зүйтэй мэт санагдаж байгаа. Америк үндэстнийг ч гэсэн янз бүрийн хэл, соёл, овог аймаг, ястан угсаатны жирийн эрээвэр хураавар нийлбэр биш олон талт бүхэл бүтэн цогцос, нэгдмэл нэг үндэстэн хэмээн үзэж хандах нь онол арга зүйн хувьд илүү нийцнэ гэдэгтэй санал нэгтэй байна. Судалгаанд ямар нэг сэдвийг аль нэг мэргэжлийн үүднээс дагнаж авч үзэхээс илүүгээр хэдэн янзын мэргэжлийн үүднээс нэлээд өргөн хүрээтэй авч үзэхийг чухалчлана. Хамгийн гол нь сүүлийн үед америк судлалд нэвтэрч байгаа шинэ арга зүй, тухайлбал, дээр дурдсанчлан аливаа шийдвэрлэгдээгүй чухлын чухал асуудлыг /problem-focused/ олон янзын мэргэжлийн чиглэлээр /multidisciplinary/ тал бүрээс нь иж бүрэн /inter-disciplinary/, цогцолбор /integral, complex/ аргаар судлаж, бясалгал бодрол

багтаамжит /think-tank/ шинжилгээ хийх судалгааны шилдэг аргагүй, арга барилд суралцах зорилт тавьж байна.

Монголын АНУ судлалын төвийн гишүүд 1991 оноос эхлэн АНУ-ын эхлэн АНУ-ын холбогдолтой эрдэм шинжилгээ, сурталчилгааны өгүүлэл бичиж, сонин сэтгүүлд нийтлүүлэн урьд яригдаж бичигдэж байснаас огт өөр санаа, дүгнэлт гаргах болсон юм.

Төвийн дэд тэргүүн, дэд доктор Ц.Батбаяр 1991 онд “АНУ-ын Азийн бодлого”, “Олон улсын харилцааны хөгжлийн хандлагууд” дэд доктор Г.Төмөрчулуун “Шинэ орчин, шинэ бодлого” гэх зэрэг өгүүлэл бичиж Дорнодахин, Олон улс судлалын хүрээлэнгийн “Дорно, Өрнө” сэтгүүлийн 1991 оны сүүлч, 1992 оны эхний дугааруудад нийтлүүлсэн. Батбаяр өгүүлэлдээ дэлхийн II дайны дараа бүрдсэн Америк, Зөвлөлт гэсэн хэт их гүрнүүдийн сөргөлдөөнөөр тодорхойлогдогч олон улсын харилцааны хоёр туйлт тогтолцоо халаагаа өгч, шинэ тогтолцоонд шилжиж байна, хоёр хэт их гүрний алинд ч гэсэн, ялангяа ЗХУ-д зэвсгээр хөөцөлдөх боломж шавхагдаж, тэдгээр улс гүрэн харилцаагаа хэвийн байдалд оруулж, хамтран ажиллах хандлага давамгайлах болов. 90-ээд оны туршид АНУ Азийн улс орнууд, түүний дотор Монголтой харилцахдаа гол төлөв худалдаа, эдийн засгийн асуудал дээр анхаарч, ардчилал хүний эрхийг хэрхэн хангаж байгаатай нь холбож үзэх хандлагатай байх болно гэсэн дүн шинжилгээ хийсэн байдаг.

Дэд доктор Г.Төмөрчулуун Монгол, Америкийн харилцаа, хамтын ажиллагааны улс төр, эрх зүйн үндэс тавигдлаа, одоо тус хоёр орны хамтын ажиллагааны шинэ арга хэлбэр, эх үүсвэрийг эрж сүвэгчлэх, ялангуяа АНУ-ын хөрөнгө оруулах чиглэлийг онцгой анхаарах нь чухал, ардчилсан Монголын ирээдүйг АНУ үгүйгээр төсөөлөхөд бэрх гэсэн санааг цохон тэмдэглэсэн байна.

Дэд доктор С.Ишдорж 1992 онд “Кремлиэс ногоон гэрэл ассаны дараа” хэмээх өгүүлэл нийтлүүлж, ХХ зууны Монгол, Америкийн харилцааны түүхийн гол асуудлыг нягталсан юм. 1921 оны ардын хувьсгалын дараа Монголд ирж байсан америкийн дипломатч Сокобиныг тагнуул туршуул

гэж үздэг байсныг няцааж тэр хүн Монголын дотоод байдал, гадаад байдалтай танилцаад “Монголчууд бол өөрийн түүх, соёлтой, хятадуудаас огт өөр үндэстэн юм” гэсэн зөв зүйтэй дүгнэлт хийж байсан үнэнч шудрага дипломатч байсныг гаргаж тавьсан байна. Мөн Монгол оронд шинээр буй болж байгаа ардчилал, зах зээлийн шинэтгэлийг АНУ аль болохоор дэмжиж, тусламж дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ эдийн засгийн бэрхшээл, хямралыг даван туулах, шилжилтийг амжилттай болгоход бусад улс орон, дэлхийн олон нийтийг татан оруулах талаар идэвхитэй ажиллаж, нааштай үр дүнд хүрч байна гэсэн дүгнэлт хийсэн байна.

Дэд доктор А.Дамдинсүрэн “Хөдөлмөр” сонины 1991 оны 7-р сарын дугаарт “Монгол, Америкийн харилцааны тухайд” хэмээх өгүүлэл нийтлүүлснийхээ дотор Ж.Лэйли зэрэг америк эрдэмтэд хүний гарал үүслийн тухай асуудалтай уялдуулж 1857 оноос эхлэн Монголыг сонирхон судалж эхэлсэн, Америкийн талаас монголыг мэдэх болсон нь XIX зууны дунд үе, дэд хагаст хамаарна, Монголын тал АНУ-г XX зууны эхэн үеэс мэдэх, сонирхох, харилцаа тогтоохыг оролдох болсон гэсэн баримт нотолгоо гаргаж ирсэн. А.Дамдинсүрэн, жич Р.Чимид нар 1916, 1918, 1922-1930 оны үест Монголд ирж “Лууны яс” хэмээх эртний галавын үлэг гүрвэл, үлэмж биетний хайгуул шинжилгээ хийж байсан Америк эрдэмтэн Вебстер, Г.Осборн, Р.Эндрюс нар тэргүүтэй шинжилгээний ангийн тухай хоёр гурван үгүүлэл бичиж, доктор Вебстер монгол хэл сайн мэддэг байсан, тэд саяхан болтол манайд яригдаж, бичигдэж байсны адил империализмын тагнуул төлөөлөгч, мэдлэг чадвараар мөхөс, ашиг хонжоо хайсан үл бүтэх этгээд байсангүй, харин “Жинхэнэ эрдэм номын ариун цагаан буянт үйлсийн төлөө Монгол орныг сонирхон судлах” зорилгоор ирж байсан их эрдэмтэд байв гэсэн дүн шинжилгээ хийсэн юм. Үнэхээр тэд шинжилгээний ангийн ажлын үр дүнг арав гаруй боть болгож хэвлүүлэхдээ хүртэл номыг англи, монгол хошмог нэртэй, монгол нэрийг нь хуучин монгол бичгээр тод томруун сайхан дармаллаж нийтлүүлсэн байдаг нь монгол улс үндэстэн, түүний нүүдэл иргэншил, бичиг соёл гүн хүндэтгэлтэй хандаж байсны гэрч нотолгоо хэмээлтэй.

Доктор Д.Цолмон ихээхэн идэвхитэй ажиллаж, 1991 оны “Ил товчоо” сонинд “Монгол улс, АНУ-ын харилцаанд учирч байсан саад ариллаа” өгүүлэл нийтлүүлж, хөндлөнгийн саад тоггорын өмнө хоёр орон юугаар хэрхэн хамтарч ажиллавал зохих тухай тодорхой санал дэвшүүлж байв. Мөн 1995 онд АНУ-д америк судлалын мэргэшил дээшлүүлж байх хугацаандаа “Америкийн олон улсын судалгаа” сэтгүүлд Монгол, Америкийн түүхэн тойм, Монгол дахь Америк судлалын асуудлаар тусгай өгүүлэл бичиж хэвлүүлсэн байна.

Сэтгүүлч эрдэмтэн С.Жамбалдорж Америкийг анх нээсэн асуудлаар нийтлүүлсэн өгүүлэлдээ индиан нар Төв Ази, Монголоос гаралтай гэсэн орос, америк эрдэмтдийн саналыг дэмжиж, Аляскийн индианы овог аймгуудын дунд зарим монгол, түрэг овгуудын нэр, түүнчлэн “Ика нүд” /их нүд/, Ика нутаг / их нутаг/, уушки /уушиг/, уналга /уналга/, адак /адаг/ гэсэн цөөнгүй монгол үг байгааг ажиглаж, монгол, америкийн эрдэмтэд индианы судлал дээр хамтран ажиллахын чухлыг дурдатган сануулсан байна.

1992 онд Монголын АНУ судлалын төв нь Америк тивийг нээсний 500 жилийн ой, Монгол, Америкийн хооронд дипломат харилцаа байгуулагдсаны 5 жилийн ойд зориулж “Америкийг анх нээсэн нь”, “Монгол, Америкийн харилцаа”, “Америкийн ардчилал, сонгуулийн тогтолцоо” сэдвүүдээр америк эрдэмтдийн оролцоотой эрдэм шинжилгээний гурван семинар хийж санал солилцоод семинарын зарим материалыг сонин сэтгүүлд нийтлүүлсэн.

Монголын АНУ судлалын төв, Олон улсын харилцааны дээд сургууль, Гадаад хэлний дээд сургуулийн удирдлага америк судлалын шинэ залуу мэргэжилтэн бэлдэх асуудал хэлэлцээд 1992 оны сүүлчээр Олон улсын харилцааны дээд сургууль дээр, 1993 онд Гадаад хэлний дээд сургууль дээр тус тус америк судлалын чиглэлийн сонгон суралцах анги нээснээс 1995-1996 онд 30-аад оюутан төгссөн. Тэдгээр оюутнуудад англи хэл, Америкийн гадаад харилцаа, газар зүй, түүх, уран зохиол, Монгол, Америкийн харилцааны лекц уншиж, семинар хийх хэрэгт манай төвийн зохицуулах зөвлөлийн гишүүн, Гадаад харилцааны дээд сургуулийн

захирал, профессор Ж.Баясах, дэд доктор Сумъяа, Гадаад хэлний дээд сургуулийн багш, дэд доктор Чинбат, Эрдэнэчимэг нарын зэрэг багш ажилтан нар ихээхэн хүчин зүтгэж, чухал үр дүнд хүрснийг цохон тэмдэглэе.

Гадаад харилцааны дээд сургууль дээр гол төлөв АНУ-ын гадаад бодлого, зах зээл, төр захиргааны байгуулал, цааз хууль, Монгол, Америкийн харилцаа, түүхийн асуудалд анхаарч, Гадаад хэлний дээд сургууль дээр америкийн хэл, утга зохиол, соёл иргэншил, зан заншил, түүхийн асуудлаар зонхилон ажиллаж эхэлснийг ажлын хуваарийн зөв зүйтэй чиглэл хэмээн үзнэ. Цаашдаа эдгээр сургууль тус тусдаа америк судлалын биеэ даасан хүчирхэг тэнхимтэй болж, сургалт, судалгаа явуулбал нэн чухал санагдана. Түүнчлэн зарим хувийн дээд сургуулиуд дээр америк судлалын анги тэнхим нээж, эдийн засаг, зах зээл, менежмент болон соёл иргэншлийн чиглэлийн сургалт, судалгаа явуулахад бүрэн болох талтай бөгөөд улсад ашигтай.

1993 оноос эхлэн Монголын АНУ судлалын төв, Гадаад харилцааны дээд сургууль, Монгол, Америкийн нийгэмлэг хүч хавсран америк судлалын тусгай сэтгүүл гаргахаар хэлэлцэн тохиролцож, зохих бэлтгэлийг хангаад 1994 онд “Америк: судалгаа, мэдээлэл” хэмээх нэртэй бэсрэгхэн сэтгүүлийн анхны дугаарыг нийтлүүлсэн, хоёрдох дугаар нь 1996 онд хэвлэгдсэн. Тус сэтгүүлийн нэр, гарчгийг англи орчуулгатай өгч, гол үгүүлэлүүдийн англи товчлолыг хавсарган нийтэлдэг. Сэтгүүлийн дугааруудад “Монгол дахь америк судлалын гараг” /Н.Ишжамц/, “АНУ-ын төрийн тогтолцоо” /Д.Цолмон/, “Жорж Кеннан: дэлхийн II дайны дараах АНУ-ын гадаад бодлогын үндэслэгчдийн нэг” /Ц.Батбаяр/, “АНУ бүрэлдэн тогтсон түүхээс” /С.Ишдорж/, “Америкийн түүх, өнөөгийн байдлаас үгүүлэх нь” /М.Хурметхан/, “Монгол, Америкийн өнөөгийн харилцаа” /Р.Отгон/, “АНУ дахь соёлын олон хэлбэрүүд” /Шерил А.Мартин/, “Роберт Л.Фиш, Арын суудлын хүн” өгүүллэг /Э.Ургамал монголчилсон/, “Гадаад улс орон дахь Америк судлалын үүсэл хөгжлийн зарим асуудал” зэрэг үгүүлэл нийтлэгдсэн.

Тус төвийн зөвлөлийн гишүүн Энхбаяр /"Америк: судалгаа, мэдээлэл"/ сэтгүүлийн хэвлэн нийтлэхэд үнэтэй тусламж үзүүлсээр ирснийг тэмдэглэх хэрэгтэй. Монголчууд АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга болон тэргүүн хатагтайн айлчлалд ихээхэн ач холбогдол өгч байгааг харгалзан сэтгүүлд Ж. Бэйкерийн хэлсэн үгнээс нэг биш удаа эш татаж, Улсын их сургууль дээр Хиллари Р.Клинтонь хэлсэн үгийг англи эхээр нь бүрэн нийтэлсэн бөгөөд сэтгүүлийн дараачийн дугаарт монгол орчуулгыг тавих гэж байгаа.

1994 онд К.Жонсонтой нийслэлийн олон нийтийн төлөөлөгчдийн хийсэн уулзалтыг манай төв зохион байгуулж, америкийн элчин сайд монголоор яриа хийж, өөрийн улсын дотоод байдал, гадаад бодлого, Америк, Монголын харилцааны асуудлуудын талаар олон зүйлийг тодруулан ярьсан явдал олны сэтгэлийг ихэд татан таалагдсан юм.

1991 оноос хойш Монголын АНУ судлалын төвийн гишүүд Монголд ирсэн Америкийн америк судлаачидтай нэлээд хэдэн удаа уулзаж ярилцан санал солилцож байсан бөгөөд 1994 онд АНУ-ын хэсэг эрдэмтэд хүрэлцэн ирж АНУ-ын гадаад бодлого, Америк, Монголын харилцаа, Индиан нарын гарваль үүсэл, амьдрал ахуйн асуудлаар лекц яриа хийсэн, ялангуяа тэдэнтэй бид хэд хэдэн удаа уулзаж тухтай ярилцсан явдал бас багагүй ач холбогдолтой болсон юм.

1994/1995 оны үест бид америк судлалын нэрт эрдэмтэн Д.К.Стивенсоны "Америкийн нийгэм, амьдрал заншил" /Штутгарт, 1987/ хэмээх 10 гаруй хэвлэлийн хуудас зохиолыг англи хэлнээс монголчилж 1996 онд хэвлүүлэн гаргасан. Тус зохиол нь Америкийн түүх, улс төр, эдийн засаг, соёл боловсрол, шинжлэх ухаан-технологи, амьдрал ахуйн бүх талыг тод томруун гаргаж, олон янзын өнгөт зураг сэлт хавсарган ойлгомжтой сайхан бичигдсэн болохоор америк судлаачид төдийгүй нийт уншигчид, олон нийтэд америкийн тухай үэнэ зөв мэдээлэл өгөх чухал ач холбогдолтой юм.

1996 он, 1997 оны эхээр манай гишүүд АНУ байгуулагдсаны 220 жил, Монгол, Америкийн хооронд дипломат харилцаа байгуулагдсаны 10 жилийн ойд зориулж

“АНУ-ын 220 жилийн түүхэн замнал” /Н.Ишжамц/, “Монгол дахь ардчилал ба АНУ” /С.Ишдорж/, “Америк орны төрх: амьдрал дээр үзсэн зүйлс” /Д.Цолмон/ гэх зэрэг судалгаа сурталчилгааны хэд хэдэн өгүүлэл бичиж сонин хэвлэлд нийтлүүлээд байгаа.

Бидний ажлын гол бэрхшээл гэвэл мөнгө, хөрөнгөгүй, мэргэжлийн боловсон хүчнээр дутмаг, Америкт очиж газар дээр нь биечлэн судалгаа хийх, гадаад орнуудад болдог америк судлалын хурал зөвлөлгөөнд оролцох боломжгүй байгаа явдал юм.

### *Цаашид тавих зорилт*

1. XX зууны үлдсэн 2-3 жилийн дотор Монгол улсыг жинхэнэ ёсны америк судлалтай болгох, ялангуяа шинэ залуу боловсон хүчин бэлдэх, одоо ажиллаж байгаа ажилтан нарыг АНУ, бусад гадаад оронд явуулж гэндэхийн америк судлалтай танилцуулах, судалгааны ажил хийх хөрөнгө мөнгөний эх үүсвэртэй болгох,

2. АНУ-д мэргэжил олсон америк судлалын мэргэжилтэн нартай болохыг нэн түрүү анхаарч ажиллах, түүнчлэн эх орны дотрох улсын, хувийн болон дотоод, гадаадын хамтарсан Улаанбаатарын их сургууль зэрэгт америк судлалын боловсон хүчин бэлдэж авах,

3. Гадаадын америк судлалын гол гол сурвалж хэрэглэгдэхүүн, судалгааны зохиол, ном сэтгүүлийг олж авч интернетийн сүлжээг ашиглан судалгааны эх сурвалжийг аль болохоор нэмэгдүүлэн бүрдүүлэх,

4. Онолын суурь судалгааны асуудал дээр онцгой анхаарал тавихын зэрэгцээ суурь, хавсарга судалгааг зохистой хослуулан, хавсрага судалгааны амьдрал, практикийн ач холбогдолыг бодож илүү далайцтай явуулах. Гэхдээ ойрын хугацаанд АНУ-ын соёл иргэншил, ардчилал, хүний эрх, чөлөөт зах зээл, менежментийн туршлага, америк маягийн амьдралын мөн чанар, өвөрмөц онцлог, хүмүүнлигийн асуудлыг ахиу судалдаг болох,

5. Давын өмнө гадаад харилцааны дээд сургууль, гадаад хэлний дээд сургуулийг тус тус америк судлалын дагнасан анги тэнхимтэй болгож, америк судлалын бүрэн программаар (full program) мэргэжилтэн бэлдэн биеэ даасан судалгаа явуулах явдлыг эрчимжүүлэх; түүнчлэн хувийн зарим их, дээд сургууль дээр америкийн судлалын анги, тэнхим байгуулах болбол дэмжлэг үзүүлэх,

6. Монголын АНУ судлалын төвийн "Америк: судалгаа, мэдээлэл" сэтгүүлийн чанарыг сайжруулж, жил тутам гаргадаг болгох. Америкийн холбогдолтой сурталчилгааг өргөжүүлэн сайжруулах шаардлагын дагуу Монгол, Америкийн нийгэмлэг, Америкийн мэдээллийн алба зэрэг байгууллагуудтай хүч хавсран өнгөт зураглал бүхий сэтгүүл гаргадаг болох асуудлыг авч үзэх.

7. АНУ судлалын төв ба их дээд сургуулиуд зэрэгт америк судлалын талаар ажиллаж байгаа эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтан нарыг АНУ, бусад гадаад орны америк судлалын байгууллагуудад урт богино хугацаагаар томилон явуулж судалгаа хийлгэх, мэргэжил дээшлүүлэх боломж олгох.

Америк судлалын боловсон хүчнийг гадаадад болдог америк судлалын хурал зөвлөлгөөнд аль болохоор оролцуулдаг болох.

8. Олон улс судлалын төвийн дотор ажиллаж байгаа гишүүдийг захиалгаар америк судлалын төсөл авч боловсруулан тодорхой санал зөвлөмж гаргадаг болгох.

9. Зарим төсөл сэдвээр гадаадын эрдэмтэд, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллах, хамтын бүтээл гаргадаг болох.

10. Дээр дурдсан америк судлалын судалгааны тэргүүний шинэ арга зүй, арга барилуудыг түргэн хугацаанд сайтар эзэмшиж, олон улсын шаардлагын түвшинд шинжилгээ судалгаа хийж чаддаг болох.

11. Монголын АНУ судлалын төвийн гишүүд, бусад байгууллага дахь америк судлаачдын чанар сайтай судалгаа, мэдээлэл, сурталчилгааны бүтээлээс гадаадын хэвлэлд нийтлүүлэх.

12.Энэ бүх ажлыг хийж гүйцэтгэхэд тууштай тусламж дэмжлэг үзүүлдэг. АНУ-ын элчин сайдын яамны дэргэдэх Америкийн мэдээллийн алба, Америкийн Азийн сан хөмрөгийн Монгол дахь төлөөлөгчийн газартай харилцаа холбоог улам бэхжүүлж, улмаар Соросын сангийн Монгол дахь салбартай ажил хэрэгч холбоо барьж, хамтран ажилладаг болох зэрэг хийвэл зохих ажил маш их байгаа болно.

Анхаарч сонссонд баярлалаа.